



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС
ХӨРӨНГИЙГ ХУРААН АВАХ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН
ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

2025

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

I сар

Судалгааг захиалагч:

Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг хянасан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

Судалгааг удирдсан:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Судалгааг гүйцэтгэсэн:

С.Нарантунгалаг

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан



АГУУЛГА

I. УДИРТГАЛ	3
II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО	4
2.1.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхойлох	4
2.1.1 Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо	25
2.1.1.1 Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох	25
2.1.1.2 Гарах зардлыг урьдчилан тооцох	29
2.1.1.3 Үр дүнг тооцох	32
2.1.1.4 Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах	33
V. ДҮГНЭЛТ	35



I. УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт “...эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.”, Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арванзургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “иргэн нь хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй.” гэж тус тус заасан нь Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл болсон байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцов.

Судалгааны зорилго. Аргачлалын 1.4.2-т заасны дагуу Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хууль /цаашид НАТХБХХАНТТХ гэх/-ийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, тэдгээр субъектэд ногдох зардлыг бууруулах боломжит хувилбарын талаар санал боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

Аргачлалд заасны дагуу, төрийн байгууллагын зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээнд, хуулийн этгээдийн зардлыг хууль тогтоомжоор төрийн байгууллагаас бусад аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах мөнгөн зардалд, иргэнд үүсэх зардлыг хууль тогтоомжоор иргэнд хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зарцуулах цаг хугацаанд тус тус үндэслэн тооцохоор заасан. Хуулийн төслөөр төрийн байгууллагад голчлон үүрэг хүлээлгэсэн буюу хөрөнгө хураах ажиллагааг төрийн байгууллагууд хэрэгжүүлэхээр заасан тул зардлын тооцоог төрийн байгууллага дээр гүйцэтгэв. Зардлын тооцоог гаргахдаа дараах нийтлэг зарчмыг баримтлав. Үүнд:

- Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Хуулийн төслөөс төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлохдоо шинээр буюу өмнө нь гүйцэтгэж байгаагүй үүрэг болон өмнө гүйцэтгэж байсан боловч тухайн үүргийг хуулийн төслөөр өргөжүүлсэн байвал тэр хүрээнд хязгаарлан зардал тээгч этгээдийн зардлыг тооцох болно. Өөрөөр хэлбэл, хуулийн төслөөр зөвхөн шинээр бий болж байгаа үүрэг эсхүл өмнө нь хэрэгжүүлж байсан үүргийн өргөжүүлсэн хэсэгт зардал тооцно.

¹ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

1. Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
2. Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
3. Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Гүйцэтгэх үүрэг гэдэгт хуулийн төслөөр төрийн холбогдох байгууллагад даалгасан бүртгэл хийх, зөвшөөрөл олгох зэрэг төрийн байгууллагаас үзүүлж буй ажил үйлчилгээг ойлгох ба Аргачлалын 4.4.6-д заасны дагуу хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан шийдвэр гаргахад төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоо хийхэд оруулаагүй болно.

Төрийн байгууллагын үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
- Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
- Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах.

2.1.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхойлох

Энэ хэсэгт төслийн зохицуулалтыг уншиж судлах замаар тодорхой үүрэг хүлээж буй байгууллага байгаа эсэхийг тодорхойлж, уг байгууллага нь ямар чиг үүрэг буюу ажил үйлчилгээ шинээр гүйцэтгэх эсхүл одоо гүйцэтгэж байгаа чиг үүрэг, ажил үйлчилгээг хуулийн төслийн дагуу өргөжсөн эсэхийг тогтоох юм.

НАТХБХХАНТХ нь хууль бус хөрөнгийг шалгах үндэслэлийг тогтоож, нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх, хянан шийдвэрлэх журам, эрх бүхий байгууллагын тогтолцоо, олон улсын хамтын ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулах зорилго бүхий дараах 11 бүлэгтэй байна. Үүнд:

- Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл
- Хоёрдугаар бүлэг. Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх зарчим
- Гуравдугаар бүлэг. Хууль бус хөрөнгө шалгах, хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогч
- Дөрөвдүгээр бүлэг. Хууль бус хөрөнгө хураан авах ажиллагаанд хүсэлт, гомдол гаргах
- Тавдугаар бүлэг. Хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааны нотлох баримт
- Зургадугаар бүлэг. Хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа
- Долдугаар бүлэг. Хөрөнгө шалгах ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулах
- Наймдугаар бүлэг. Шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналт
- Есдүгээр бүлэг. Хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа
- Аравдугаар бүлэг. Олон улсын хамтын ажиллагаа
- Арван нэгдүгээр бүлэг. Бусад зохицуулалт

Иймд хуулийн төслөөс зохицуулалтуудыг сонгохдоо дээрх агуулгыг бүхэлд нь хамруулж, Аргачлалын 3.2-т заасны дагуу хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж

байгаа голлох ач холбогдолтой болон ажил, үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой зохицуулалтуудыг сонголоо. Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар зардал үүсгэж болохуйц эсхүл тодорхой байгууллага, субъектэд шинээр үүрэг хүлээлгэсэн, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор хэлтэс, нэгж байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон болно.

Аргачлалын 4.4.6.-д заасны дагуу хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан шийдвэр гаргахад төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоо хийхэд оруулахгүй. Үүнд:

45.1.Шалгах ажиллагаа болон прокурорын хяналтын явцад үйлдэх тэмдэглэлийн болон шийдвэрийн маягтыг Улсын ерөнхий прокурор батална.

53.6.Энэ хуульд заасан эвлэрлийн гэрээ байгуулснаар шалгах ажиллагааг зогсоож болно. Эвлэрлийн гэрээ байгуулах журмыг Улсын ерөнхий прокурорын тушаалаар батална.

НАТХБХХАНТХ-ийн төсөл дэх, төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгт /ажил үйлчилгээ/ хамаарах дараах зохицуулалтууд байна. Үүнд:

Хүснэгт 1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхойлох нь

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ
9 дүгээр зүйл.Прокурор 9.1.Прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Прокурорын тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.1.2. энэ хуульд заасан журмаар ирүүлсэн хөрөнгө, орлогын мэдүүлэгт Авлигатай тэмцэх газраар хяналт, дүн шинжилгээ хийлгэх.	Авлигатай тэмцэх газар	Хөрөнгө , орлогын мэдүүлэгт хяналт, дүн шинжилгээ хийх
9 дүгээр зүйл.Прокурор 9.2.Прокурорыг шүүхийн шатанд зохигч буюу нэхэмжлэгч гэх бөгөөд шүүхийн шатанд прокурор Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 26 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.	Прокурор	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох
10 дугаар зүйл. Мөрдөгч 10.2.Мөрдөгч нийтийн албан тушаалтны хөрөнгийн эх үүсвэрийг тогтоох талаар энэ хуульд заасан ажиллагаа явуулна.	Мөрдөгч	Хөрөнгө шалгах ажиллагаа явуулах, нийтийн албан тушаалтны хөрөнгийн эх үүсвэрийг тогтоох
13 дугаар зүйл. Гэрч 13.3.Гэрч дуудсан цагт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг шүүхийн шийдвэрээр албадан ирүүлнэ.	Цагдаа	Гэрчийг албадан ирүүлэх
13 дугаар зүйл. Гэрч 13.7.Мэдүүлэг авахаас өмнө энэ хуульд заасан гэрчийн эрх, үүргийг тайлбарлаж өгнө.	Мөрдөгч	Гэрчийн эрх, үүргийг гэрчид тайлбарлаж өгөх
15 дугаар зүйл.Шинжээч 15.2.Шинжээч нь прокурор, мөрдөгчийн тавьсан асуултын дагуу тусгай мэдлэг,	Шинжээч	Дүгнэлт гаргах

мэргэжлийн хүрээнд шинжилгээг тал бүрээс нь бүрэн бодитой хийж, тогтоосон хугацаанд шинжлэх ухааны үндэслэл бүхий дүгнэлтийг бичгээр гаргана.		
15 дугаар зүйл.Шинжээч 15.3.Дүгнэлт гаргасан шинжээч нь мэдүүлэг авахаар шүүх, прокуророос дуудсан цагт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг хуульд заасны шүүхийн шийдвэрээр албадан ирүүлнэ.	Цагдаагийн байгууллага	Шинжээчийг албадан ирүүлэх
16 дугаар зүйл.Мэргэжилтэн 16.2.4.гүйцэтгэсэн ажлын хөлс, зардлыг авах /албан үүргийнхээ хувиар оролцсон бол энэ заалт хамаарахгүй/;	Төрийн байгууллага	Мэргэжилтний гүйцэтгэсэн ажлын хөлс, зардлыг өгөх
17 дугаар зүйл.Орчуулагч, хэлмэрч 17.2.3.гүйцэтгэсэн ажлын хөлс, зардлыг авах.	Төрийн байгууллага	Орчуулагч, хэлмэрчийн ажлыг хөлс, зардлыг өгөх
20 дугаар зүйл.Хүсэлтийг шийдвэрлэх 20.1.Хуульд заасан журмын дагуу гаргасан хүсэлт нь хөрөнгө хураан авах ажиллагааны явцад оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдолтой бол бүрэн, эсхүл хэсэгчлэн хангах, эсхүл хангахаас татгалзах тухай шүүх, прокурор, мөрдөгч шийдвэр гаргана. 20.2.Хүсэлтийг хангах үндэслэл нь тодорхой бол даруй, шалгах шаардлагатай тохиолдолд түүнийг гаргаснаас хойш ажлын 5 өдрийн дотор хангах эсэхийг шийдвэрлэнэ.	Шүүх, прокурор, мөрдөгч	Хүсэлтийг шийдвэрлэх
22 дугаар зүйл.Мөрдөгч, прокурорын шийдвэр, ажиллагаанд гаргасан гомдлыг хянах 22.2.Гомдлыг хүлээн авсан прокурор 14 хоногийн дотор, нэмэлт материал шалгах, эсхүл бусад арга хэмжээ авах бол 21 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ. 22.3.Гомдлыг хянасан албан тушаалтан, прокурорын зүгээс мөрдөгч, прокурорын шийдвэр, ажиллагааг хүчингүй болгох, өөрчлөх, эсхүл гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай шийдвэр гаргана. 22.4.Гомдол гаргагчид гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн, түүний үндэслэл, уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шийдвэрийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор дээд шатны прокурорын газарт гомдол гаргаж болохыг тайлбарлана.	Прокурор	Мөрдөгч, прокурорын шийдвэр, ажиллагаанд гаргасан гомдлыг хянах
24 дүгээр зүйл.Хүсэлт, гомдлыг хавтаст хэрэгт хавсаргах 24.1.Энэ хуульд заасны дагуу гаргасан хүсэлт, гомдол, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн баримт, тэмдэглэл, холбогдох бүх материалыг хавтаст хэрэгт хавсаргана.	Мөрдөгч	Хүсэлт, гомдлыг хавтаст хэрэгт хавсаргах

26 дугаар зүйл.Нотлох баримт цуглуулах 26.1.Мөрдөгч, прокурор хөрөнгө шалгах ажиллагаа явуулахдаа хаалттай болон хязгаарлалттай мэдээлэл агуулсан баримт бичиг, мэдээллийг цуглуулж, мэдээллийг хамгаалахад шаардлагатай арга хэмжээг авна. 26.2.Мөрдөгч нь прокурорын зөвшөөрлөөр нотариат, банк, даатгалын болон арилжааны нууц, банк, банк бус санхүүгийн байгууллага дахь гүйлгээ, зээлийн нэмэлт мэдээлэл гаргуулан авна. 26.3.Прокурор саналыг хүлээн авснаас хойш даруй зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ. Татгалзсан шийдвэр гаргасан тохиолдолд үндэслэлийг тогтоолд тодорхой зааж өгнө.	Мөрдөгч, прокурорын байгууллага	Нотлох баримт цуглуулах
30 дугаар зүйл.Шалгах ажиллагаа явуулах 30.1.Хууль бус хөрөнгө шалгах тусгайлсан нэгж нь гомдол, мэдээллээр болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, иргэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, эсхүл мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хууль бус хөрөнгийг шалгах үндэслэл байгааг илэрснийг мэдэгдсэн даруй хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа (цаашид “шалгах ажиллагаа” гэх)-г явуулахаар холбогдох баримт бичиг, мэдээллийн хамт прокурорт шалгах ажиллагаа явуулах тогтоол (цаашид “тогтоол” гэх) гаргах санал хүргүүлнэ. 30.2.Тогтоол гарснаас хойш нэн даруй харьяа прокурорын байгууллагын орлогч прокурорт хүргүүлэх бөгөөд тогтоолыг хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор харьяаллын дагуу шилжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. 30.3.Тогтоолыг хүлээн авахаас татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрвөл дээд шатны прокурорт нэн даруй санал хүргүүлэх бөгөөд дээд шатны прокуророос саналыг үндэслэлтэй гэж үзвэл долоо хоногийн дотор шийдвэрийг хүчингүй болгож, тогтоол гаргана. 30.5.Энэ хуулийн 30.1-д заасан баримт бичиг, мэдээлэл нь албаны нууцад хамаарна. 30.6.Прокурор шалгах ажиллагааг явуулах тогтоолд хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх үндэслэл, хууль бус хөрөнгийг өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн мэдээллийг тодорхой тусгана. 30.7.Харьяаллын дагуу шилжүүлсэн баримт бичиг, мэдээллээр тогтоогдоогүй хууль бус хөрөнгө байгаа нь нэмж илэрсэн тохиолдолд тухайн хөрөнгөд	Хууль бус хөрөнгө шалгах тусгайлсан нэгж	Шалгах ажиллагаа явуулах

холбогдуулан шалгах ажиллагааг хамтад нь явуулна. 30.8.Шалгах ажиллагааны явцад нийтийн албан тушаалтан, эсхүл түүний хамаарал бүхий этгээдийн хөрөнгө, хууль ёсны орлого, амьжиргааны зардал, өвлөсөн хөрөнгийн нотолгоо, гуравдагч этгээдэд шилжүүлсэн хөрөнгө, нөхөн төлбөрийн талаарх баримтыг цуглуулна. 30.9.Шалгах ажиллагааг прокурорын тогтоолоор эхлүүлэх бөгөөд прокурор шалгах ажиллагаанд хяналт тавина. 30.10.Энэ хуульд заасан баримтыг прокурорын даалгавраар, эсхүл мөрдөгч өөрийн санаачилгаар цуглуулна. 30.11.Баримт нотолгоо болох эд зүйлийг түр хугацаагаар хурааж авч болно.		
32 дугаар зүйл.Үзлэг хийх 32.1.Хөрөнгө шалгах ажиллагаанд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоох, тодруулах зорилгоор хүний бие, эд зүйл, баримт бичиг, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, мал, амьтан, тодорхой газар, орон байранд үзлэг хийнэ.	Мөрдөгч	Үзлэг хийх
33 дугаар зүйл.Нэгжлэг хийх 33.1.Мөрдөгч хөрөнгө шалгах ажиллагаанд ач холбогдолтой баримт бичиг, эд зүйл, эсвэл нотлох баримт байна гэх хангалттай үндэслэл байвал тэдгээрийг илрүүлэхээр прокурорын зөвшөөрөлд заасан орон байр, бусад газар, хүний биед нэгжлэг хийнэ.	Мөрдөгч	Нэгжлэг хийх
34 дүгээр зүйл.Тайлбар, мэдүүлэг 34.1.Мөрдөгч нь холбогдогч, гэрч, шинжээч, мэргэжилтэн, бусад оролцогчоос хөрөнгө шалгах ажиллагаанд ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар, шинжээч, мэргэжилтнээс гаргасан дүгнэлт, оролцсон ажиллагааных нь талаар тайлбарлуулах, эсхүл тодруулах зорилгоор тайлбар, мэдүүлэг авч болно.	Мөрдөгч	Тайлбар, мэдүүлэг авах
35 дугаар зүйл.Тайлбар, мэдүүлгийг газар дээр нь шалгах 35.1.Илэрсэн нөхцөл байдлыг шалгах, явсан замыг тогтоох, зааж өгсөн газрыг шалгах, урьд өгсөн тайлбар, мэдүүлгийн үнэн зөвийг харьцуулан тогтоох зорилгоор тайлбар, мэдүүлгийг газар дээр нь шалгаж болно.	Мөрдөгч	Тайлбар, мэдүүлгийг газар дээр нь шалгах
36 дугаар зүйл.Таньж олуулах 36.1.Мөрдөгч хөрөнгө шалгах ажиллагаанд ач холбогдолтой нөхцөл байдлыг тогтоох, тодруулах зорилгоор хүн, мал, амьтан, эд зүйл, тодорхой газар, орон байрыг таньж олуулж болно.	Мөрдөгч	Таньж олуулах
37 дугаар зүйл.Шинжилгээ хийлгэх 37.1.Хөрөнгө шалгах ажиллагааны явцад эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоохоор, эсхүл тусгай мэдлэг зайлшгүй шаардлагатай бол шүүх, прокурор,	Шүүх, прокурор, мөрдөгч	Шинжилгээ хийлгэх

мөрдөгч шийдвэр гаргаж шинжилгээ хийлгэнэ.		
38 дугаар зүйл.Эд хөрөнгө битүүмжлэх 38.1.Хохирлыг нөхөн төлүүлэх, хууль бус хөрөнгийг хураах, нөхөн төлүүлэх зорилгоор нийтийн албан тушаалтны хөрөнгийг шүүх, прокурорын шийдвэрээр битүүмжилнэ.	Шүүх, прокурор, мөрдөгч	1. Шүүх, прокурор шийдвэр гаргах; 2. Эд хөрөнгө битүүмжлэх
39 дүгээр зүйл.Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах 39.1.Мөрдөгч хэрэгт ач холбогдолтой хөрөнгийг нуух, устгах, эрх шилжүүлэх үндэслэл бүхий сэжиг байвал прокурорын зөвшөөрлөөр хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах ажиллагааг явуулна.	Мөрдөгч	Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах
40 дүгээр зүйл.Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах 40.1.Мөрдөгч хаалттай болон хязгаарлалттай мэдээлэл эсэхээс үл хамааран эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий аливаа мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргуулан авна.	Мөрдөгч	Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах
41 дүгээр зүйл.Түр хураан авах 41.1.Хөрөнгө шалгах ажиллагааны явцад дараах үндэслэл байвал хууль бус байж болзошгүй хөрөнгийг хамгаалах зорилгоор түр хураан авч болно: 41.1.1.хөрөнгийг устгах, захиран зарцуулах, өмчлөгч, эзэмшигчийг өөрчлөх; 41.1.2.хөрөнгийн үнийг илтэд нөлөөлөх бодит нөхцөл бий болсон; 41.1.3.хөрөнгийг гэмт хэрэг үйлдэхэд ашиглах боломжтой; 41.1.4.тухайн хөрөнгө үрэгдэх, тоногдох, шинж чанарыг өөрчлөх болон хөрөнгийг цаашид хураах боломжгүй болгох бусад эрсдэл байвал.	Мөрдөгч	Түр хураан авах
41 дүгээр зүйл.Түр хураан авах 41.2.Түр хураан авахад мөрдөгч, прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ. 41.3.Түр хураан авах тогтоолд тухайн хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчийн мэдээлэл, хөрөнгийн талаарх мэдээлэл, хөрөнгийн баримт бичиг, хууль бус хөрөнгө гэж үзэх үндэслэлтэй нөхцөл байдал, тухайн хөрөнгийг түр хураан авах шаардлага, нөхцөл байдал, түр хураах хугацааны талаар тусгана.	Шүүх, мөрдөгч, прокурор	1. Мөрдөгч, прокурор санал гаргах 2. Шүүх түр хураан авах тухай шийдвэр гаргах
42 дугаар зүйл.Түр хураан авсан хөрөнгийг шийдвэрлэх 42.1.Хөрөнгө шалгах ажиллагааны явцад түр хураан авсан хөрөнгийн эх үүсвэр нь хууль бус болох нь тогтоогдвол мөрдөгч, прокурорын саналыг үндэслэн шүүгч	Шүүх	1. Мөрдөгч, прокурор санал гаргах 2. Түр хураан авсан хөрөнгийг “Хөрөнгө эрхлэн удирдах нэгж”-д

тухайн хөрөнгийг битүүмжилж, хадгалалт хамгаалалтыг “Хөрөнгө эрхлэн удирдах нэгж”-д хариуцуулахаар шийдвэр гаргана.		хариуцуулах шийдвэр гаргах
42 дугаар зүйл.Түр хураан авсан хөрөнгийг шийдвэрлэх 42.2.Тухайн шийдвэрийг прокурор хөрөнгийн эзэмшигч, өмчлөгч, ашиглагч, холбогдогч, түүний өмгөөлөгчид 5 хоногийн дотор танилцуулна. 42.3.Түр хураан авсан хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны болох нь тогтоогдвол мөрдөгч эзэмшигч, өмчлөгч, ашиглагчид нь буцаан олгоно.	Прокурор	Түр хураан авсан хөрөнгийн шүүхийн шийдвэрийг танилцуулах
46 дугаар зүйл.Шалгах ажиллагааны хэргийн материал 46.2.Мөрдөгч, прокурор, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь оролцогч, бусад оролцогчоос гаргасан хүсэлт, гомдол, мэдээлэл, шалгах ажиллагааны шийдвэр, бусад баримт бичиг, эд зүйлийг тэмдэглэл үйлдэж, эсхүл төрийн албан хэрэг хөтлөх журмын дагуу бүртгэж, хэргийн материалд тусгаж, хавсаргана.	Мөрдөгч, прокурор, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга	Шалгах ажиллагааны хэргийн материалыг бүртгэж, хөтлөх
47 дугаар зүйл.Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах 47.1.Шалгах ажиллагаанд ач холбогдолтой нөхцөл байдлыг тогтоох зорилгоор мөрдөн шалгах нууц ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу прокурорын зөвшөөрлөөр явуулах даалгаврыг эрх бүхий мөрдөгчөөр хийлгэнэ.	Тагнуулын байгууллага дахь тусгайлсан нэгжийн мөрдөгч	1. Прокурор зөвшөөрөл олгох; 2. Мөрдөгч мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах.
48 дугаар зүйл.Прокурорын зөвшөөрөл 48.1.Энэ хуулийн 31 дүгээр зүйлийн 3, 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шалгах ажиллагаа явуулах тухай мөрдөгчийн тогтоолд дараахь зүйлийг тусгана: 48.1.1.санал гаргасан мөрдөгчийн нэр; 48.1.2.шалгах ажиллагааны төрөл; 48.1.3.шалгах ажиллагаа явуулах зорилго, үндэслэл; 48.1.4.шалгах ажиллагаанд хамрагдах хүн, хуулийн этгээд, байгууллага, объект; 48.1.5.шалгах ажиллагаа явуулах газар, нэвтрэх, дамжин орох орон байрны хаяг, эзэмшил газрын байршил; 48.1.6.шалгах ажиллагаа явуулах хугацаа; 48.1.7.шалгах ажиллагааг шөнийн цагаар явуулах бол энэ тухай үндэслэл бүхий тайлбар. 48.2.Прокурор энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан саналыг хүлээн авсан даруй шалгах ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох эсэх тухай шийдвэр гаргаж,	Прокурор	Мөрдөн шалгах ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох

мөрдөгчийн тогтоолтой танилцан гарын үсэг зурж баталгаажуулна.		
50 дугаар зүйл.Шалгах ажиллагааны нууцлал, нийтэд мэдээлэх 50.1.Хөрөнгө шалгах нэгж шалгах ажиллагааны оролцогч болон тухайн ажиллагааны талаар олж мэдсэн бусад этгээдэд шалгах ажиллагааны мэдээллийг зөвшөөрөлгүйгээр задруулахгүй байх үүрэг, үүргээ биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан хариуцлагын талаар мэдэгдэнэ. 50.2.Хөрөнгө шалгах ажиллагааны талаарх мэдээллийг прокурорын зөвшөөрөлтэйгээр улирал тутам нийтэд мэдээлнэ.	Хөрөнгө шалгах нэгж	Шалгах ажиллагааны нууцлал, нийтэд мэдээлэх
52 дугаар зүйл.Хөрөнгө шалгах ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулах 52.1.Хөрөнгө шалгах ажиллагааны явцад холбогдогч нь хөрөнгийн эх үүсвэрийг хууль бус болохыг хүлээн зөвшөөрч сайн дураар тухайн хөрөнгийг хураалгахыг зөвшөөрсөн тохиолдолд шалгах ажиллагааг дуусгаж болно. 52.2.Хууль бус хөрөнгө өмчлөгч, эзэмшигч, холбогдогч нь хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх хүсэлтээ хөрөнгө шалгах ажиллагааны аль ч үед гаргаж болно. 52.3.Хөрөнгө шалгах ажиллагааны явцад мөрдөгчид гаргасан энэ хуулийн 52.2-т заасан хүсэлтийг прокурорт шууд шилжүүлнэ. 52.4.Хууль бус хөрөнгийн үнийг тухайн үеийн зах зээлийн үнийг үндэслэн инфляцийн түвшинтэй уялдуулан тооцно. Хүсэлтийн дагуу хууль бус хөрөнгийг улсад биет хэлбэрээр шилжүүлэх бөгөөд хэрэв хууль бус хөрөнгийн өмчлөгчийн саналаар, эсхүл тухайн хөрөнгө өөр хөрөнгөтэй нийлсэн, хөрөнгө салгах боломжгүй тохиолдолд түүний зах зээлийн үнийг тооцож, нөхөн төлнө. 52.5.Хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх тухай бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн хэргийг прокурор шүүхэд шилжүүлнэ. 52.6.Хүсэлтийг шүүх Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар шийдвэрлэнэ.	Прокурор, шүүх	Хөрөнгө шалгах ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулах
53 дугаар зүйл.Прокурорын шийдвэр 53.1.Прокурор шалгах ажиллагааны явцад цугларсан болон гуравдагч этгээдээс ирүүлсэн нотлох баримтад үндэслэн шийдвэр гаргана. 53.2.Хууль бус хөрөнгө байна гэж үзэх хангалттай үндэслэл байгаа бол прокурор тухайн хууль бус хөрөнгийг хураан авах	Прокурор	Прокурор шийдвэр гаргах

нэхэмжлэл шүүхэд гаргах тухай шийдвэр гаргана. 53.3.Цуглуулсан материалд үндэслэн энэ хуульд заасан журмын дагуу хураан авах хууль бус хөрөнгө байна гэж дүгнэх үндэслэлгүй бол прокурор шалгах ажиллагааг зогсоох тухай шийдвэр гаргана. 53.4.Шалгах ажиллагааг зогсоох тухай шийдвэрийн үндэслэлтэй дээд шатны прокурор танилцана. 53.5.Шалгах ажиллагааг зогсоох тухай прокурорын шийдвэр үндэслэлгүй бол үргэлжлүүлэн шалгах, эсхүл анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргах, эсхүл гэмт хэргийн шинжтэй бол харьяаллын дагуу шилжүүлэхийг прокурорт даалгана.		
55 дугаар зүйл.Нэхэмжлэл гаргах 55.1.Хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх нэхэмжлэл(цаашид “нэхэмжлэл” гэх)-ийг прокурор иргэний хэргийн анхан шатны шүүхэд Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан харьяаллын дагуу гаргана. 55.2.Прокурор нэхэмжлэл гаргахдаа нэхэмжлэлийн үндэслэл, шаардлагыг тодорхойлж, холбогдох баримтыг хавсарган нэхэмжлэлийг шүүхэд хүргүүлнэ.	Прокурор	Нэхэмжлэл гаргах
56 дугаар зүйл.Шүүх хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай шийдвэр гаргах 56.1.Шүүхээс хөрөнгө шалгах ажиллагааны явцад цугларсан нотлох баримтыг үндэслэн энэ хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу нэхэмжлэлийг шийдвэрлэнэ.	Шүүх	Шүүх хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай шийдвэр гаргах
60 дугаар зүйл.Гадаад улсаас хүлээн авсан хүсэлтийг биелүүлэх журам 60.1.Ерөнхий прокурорын газар нь гадаад улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн, хөрөнгө илрүүлэн тогтоох, хөрөнгийн мэдээлэл авах хүсэлтийг хангах зорилгоор хуульд заасан холбогдох арга хэмжээг авч болно. 60.2.Хууль бус хөрөнгө хураах тухай гадаад улсын шүүхийн шийдвэр, тус шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн арга хэмжээг олон улсын гэрээ болон эрх зүйн харилцан туслалцааны үндсэн дээр хүлээн зөвшөөрч болно. 60.3.Ерөнхий прокурорын газар нь гадаад улсын эрх бүхий байгууллагаас хөрөнгө хураан авахтай холбогдох шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг хүлээж авсан даруй тухайн шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэхээр хуульд заасны дагуу гүйцэтгэх хуудас гаргуулах тухай хүсэлтийг шүүхэд гаргана.	Ерөнхий прокурорын газар	Шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэхээр хуульд заасны дагуу гүйцэтгэх хуудас гаргуулах тухай хүсэлтийг шүүхэд гаргах

60.4.Ерөнхий прокурорын газар нь хийсэн ажиллагаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудасны талаар хүсэлт илгээсэн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. 60.5.Олон улсын гэрээ, эсхүл энэ хуульд заасны дагуу гадаад улсын эрх бүхий байгууллагаас хүлээн авсан хүсэлтийг биелүүлэх нь дотоодын хууль тогтоомжтой харшлах буюу бусад шалтгаанаар боломжгүй бол гадаад улсын холбогдох байгууллагад хүсэлтийг биелүүлэх боломжгүй болсон шалтгааны талаар мэдэгдэнэ.		
62 дугаар зүйл.Хүсэлт илгээх журам 62.1.Гадаад улсын нутаг дэвсгэрт байгаа хөрөнгийн талаар мэдээлэл авах, хөрөнгийг битүүмжлэх, хөрөнгийн хөдөлгөөнийг хязгаарлах, түр хураан авах, хураан авах талаар прокурор, шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэх арга хэмжээ авах хүсэлтийг Ерөнхий Прокурорын газар гадаад улсын эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.	Ерөнхий прокурорын газар	Шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэх арга хэмжээ авах хүсэлтийг гадаад улсын эрх бүхий байгууллагад хүргүүлэх
63 дугаар зүйл.Мэдээллийн сан, тайлан 63.1.Хууль бус хөрөнгө хураах ажиллагааны цахим мэдээллийн санг прокурорын байгууллага хариуцан эрхлэн хөтөлнө. 63.2.Энэ хуулийн 63.1-д заасан мэдээллийн сан нь дараах мэдээллээс бүрдэнэ: 63.2.1.шалгах ажиллагаанд хамрагдсан хөрөнгө, түүний байршил, хэлбэр, шалгах ажиллагааны үеийн үнэлгээ, тус хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчийн мэдээлэл; 63.2.2.түр хураасан хөрөнгө, түүний байршил, хэлбэр, шалгах ажиллагааны үеийн үнэлгээ, тус хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчийн мэдээлэл; 63.2.3.хураан авч улсын орлого болгосон хөрөнгө, түүний байршил, хэлбэр, шалгах ажиллагааны үеийн үнэлгээ, тус хөрөнгийн өмчлөгч, эзэмших чийн мэдээлэл, түүний захиран зарцуулалт, захиран зарцуулалтаас олсон орлого; 63.2.4.түр хураасан хөрөнгийг зайлшгүй шаардлагаар худалдан борлуулсан хэлбэр, борлуулснаас олсон орлого, орлого төвлөрүүлсэн данс. 63.3.Прокурор нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан мэдээллийн нууцыг хангах үүргээ биелүүлж, хууль бус хөрөнгө хураах ажиллагаа, түүний үр	Прокурорын байгууллага	Хууль бус хөрөнгө хураах ажиллагааны цахим мэдээллийн санг хөтлөх

дүнгийн талаарх тайланг жил бүр нийтэлнэ.		
---	--	--

Төрд үүсэх зардлыг тодорхойлохын тулд байгууллага тус бүрийн “хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх”-д гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Хуулийн төслийн 7 дугаар зүйлд хууль бус хөрөнгийг хураан авах ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагуудыг тодорхойлсон. Үүнд:

7.1.Энэ хуулийн 3.1-д заасан хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааг шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газар, цагдаа, тагнуулын байгууллага дахь тусгайлсан нэгжийн мөрдөгч хэрэгжүүлнэ.

3.1.Энэ хууль нь нийтийн албан тушаалтан холбогдсон, гэмт хэргийн улмаас бий болсон, энэ хуульд заасан хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа явуулах үндэслэл байгаа тохиолдолд үйлчилнэ.

7.2.Энэ хуулийн 3.2-т заасан ажиллагааг шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газрын мөрдөгч хэрэгжүүлнэ.

3.2.Энэ хууль нь Авлигын эсрэг хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчиж олсон хөрөнгө, орлогыг хураахад нэгэн адил үйлчилнэ.

Хуулийн төслийн 7.1, 7.2-т заасны дагуу хөрөнгө шалгах ажиллагааг явуулах эрх бүхий байгууллагуудын мөрдөгчийн гүйцэтгэх үүргийг Хүснэгт 2-т оруулав.

Хүснэгт.2 Мөрдөгчийн стандарт үйл ажиллагаа

Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа
Хөрөнгө шалгах ажиллагаа явуулах эрх бүхий Мөрдөгч (Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн байгууллага, Тагнуулын байгууллага)	Шалгах ажиллагаа явуулах хэрэг нээх;	Хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа явуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоох; <i>Хуулийн төслийн 28 дугаар зүйл</i>
		Прокурорт даруй мэдэгдэх;
		Прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх;
		Прокурорт танилцуулах;
	Шалгах ажиллагааны хэргийн материалыг бүртгэж, хөтлөх;	Хүсэлт, гомдол, мэдээлэл, шалгах ажиллагааны шийдвэр, бусад баримт бичиг, эд зүйлийн талаар тэмдэглэл үйлдэх;
		Төрийн албан хэрэг хөтлөх журмын дагуу бүртгэх;
		Хүсэлт, гомдол, мэдээлэл, шалгах ажиллагааны шийдвэр, бусад баримт бичгийг хэргийн материалд тусгаж, хавсаргах;
	Хөрөнгө шалгах тодорхой төрлийн ажиллагаа явуулах санал прокурорт гаргах;	Нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, тодорхой төрлийн мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах ажиллагааг явуулах саналыг бичих;
		Саналыг прокурорт хүргүүлэх;

	Шалгах ажиллагаанд ач холбогдол бүхий этгээдийг дуудан ирүүлэх;	Шалгах ажиллагаанд ач холбогдол бүхий этгээдийг тогтоох;
		Тухайн этгээдийн холбогдох мэдээллийг хайх;
		Утсаар холбогдох;
		Зайлшгүй шаардлагатай тохиолдолд прокурорын мэдэгдэх хуудас авах
		Прокурорын мэдэгдэх хуудас хүргүүлэх
	Шинжилгээ хийлгэхээр шинжээч томилох;	Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд ШШТХ-ийн 8.2-т заасан этгээдэд шинжилгээ хийлгэх санал тавих;
		Шинжээчийн хувийн баримт бичиг, тусгай мэдлэг, мэргэжил, чадварыг нотолсон баримт бичиг, шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзах үндэслэл, шинжээчээр ажиллахыг зөвшөөрч байгаа эсэхийг урьдчилан тодруулж баримтжуулах;
		Шинжилгээ хийлгэх тухай шийдвэр гаргах. Шүүх шинжилгээний тухай хуулийн 7.3-т заасан зүйлийг тусгаж бичих; 7.3.Шинжилгээ хийлгэх шийдвэрт дараах зүйлийг тусгана: 7.3.1.шинжилгээ хийлгэх үндэслэл; 7.3.2.шинжилгээний төрөл, хэлбэр; 7.3.3.энэ хуулийн 16.7-д заасан жишиг хугацааны хүрээнд тогтоосон шинжилгээ хийлгэх хугацаа; 7.3.4.шинжилгээ хийх байгууллагын нэр; 7.3.5.шинжилгээний байгууллагаас бусад этгээдээр шинжилгээ хийлгэх бол байгууллага, шинжээчийн нэр; 7.3.6.шинжээчид тавих асуулт; 7.3.7.хэмжээ, хаяг, байршил зэрэг шинжилгээний объектын талаарх мэдээлэл.
		Шинжилгээ хийлгэх шийдвэрийг гардуулан өгөх;
		Шинжээчийн эрх, үүрэг, хариуцлагыг урьдчилан сануулж, гарын үсэг зуруулах;
	Оролцогчийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх;	Гэрч, шинжээч, мэргэжилтний өөрийн болон бусдын аюулгүй байдлаа хангуулах талаарх хүсэлтийг хүлээн авах;

		Хүсэлт, гомдлыг амаар, эсхүл бичгээр гаргах ба амаар гаргасан бол тэмдэглэлд тусгаж, хүлээн авсан албан тушаалтан, хүсэлт, гаргагч гарын үсэг зурах;
		Хүсэлтийг хуульд заасан журмын дагуу гаргасан, үндэслэлтэй гэж үзвэл гэрч, хохирогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээс бусад биеийн байцаалтыг мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгахгүйгээр тусад нь бичиж битүүмжлэн хавтаст хэрэгт хавсаргах;
		Хүсэлт, гомдол, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн баримт, тэмдэглэл, холбогдох бүх материалыг хавтаст хэрэгт хавсаргах;
	Холбогдогч, гэрч, шинжээч, мэргэжилтэн, бусад оролцогчоос тайлбар, мэдүүлэг авах	Мэдүүлэг өгөх гэж байгаа хүнд өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэйг нь тайлбарлах ба санаатай худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай сануулах;
		Мэдүүлэг авахад орчуулагч, хэлмэрч оролцуулах бол түүнд эрх, үүргийг тайлбарлан, санаатайгаар худал орчуулах, эсхүл хэлмэрчилбэл хүлээлгэх хариуцлагыг урьдчилан сануулж, тэмдэглэлд гарын үсэг зуруулах;
		Мэдүүлгийг бичгээр хөтөлж, баримтжуулах;
		Оролцогчийн өгсөн мэдүүлгийг өөрт нь танилцуулж, гарын үсэг зуруулах;
	Үзлэг хийх	Эд зүйл, баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд эзэмшигчийг байлцуулна. Эзэмшигчийг байлцуулах боломжгүй бол хөндлөнгийн хоёр гэрчийг байлцуулж, эсхүл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлэх;
		Мөрдөгч эд мөрийн баримтыг прокурорын зөвшөөрлөөр түр хураан авна.
		Мөрдөгч эд мөрийн баримт хураан авах ажиллагааг эхлэхийн өмнө хураан авах тухай прокурорын шийдвэрийг танилцуулж, хураан авах эд мөрийн баримтыг сайн дураар гаргаж өгөх, зааж өгөх боломжийг тухайн хүнд олгох.
	Нэгжлэг хийх	Орон байр, бусад газарт нэгжлэг хийхэд прокурорын зөвшөөрөл авах

		Нэгжлэг хийхийн өмнө эд зүйл, баримт бичгийг сайн дураар заах, гаргаж өгөх боломжийг тухайн хүнд олгох
		Нэгжлэг хийх
	Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах	Прокурорын зөвшөөрөл авах
		Үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хянах;
		Үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахыг зохих байгууллагад даалгах.
	Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах	Хэрэгт ач холбогдол бүхий баримт бичгийг тодорхойлох
		Баримт мэдээлэл хадгалагдаж байгаа байгууллага, албан тушаалтан, хүнд албан бичиг хүргүүлэх
		Төрийн нууц, хувь хүний эрүүл мэнд, захидал харилцааны нууцтай холбоотой эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авах
	Хууль бус байж болзошгүй хөрөнгийг түр хураан авах	Дараах үндэслэлүүдийг шалгах: 41.1.1.хөрөнгийг устгах, захиран зарцуулах, өмчлөгч, эзэмшигчийг өөрчлөх; 41.1.2.хөрөнгийн үнийг илтэд нөлөөлөх бодит нөхцөл бий болсон; 41.1.3.хөрөнгийг гэмт хэрэг үйлдэхэд ашиглах боломжтой; 41.1.4.тухайн хөрөнгө үрэгдэх, тоногдох, шинж чанарыг өөрчлөх болон хөрөнгийг цаашид хураах боломжгүй болгох бусад эрсдэл байвал.
		Түр хураан авах тухай хүсэлт гаргах

		Зарим онцлох эд зүйл, үнэт эдлэл, түүх, соёлын дурсгалт зүйлийг хураан авахад мэргэжилтнийг оролцуулах
		Баримт бичгийг эхээр нь, шаардлагатай бол хууль ёсны эзэмшигчид эхийг нь буцаан олгож, хуулбарыг хэрэгт хавсарган тэмдэглэлд тусгах.
		Хураан авсан эд мөрийн баримтын жагсаалт, тэмдэглэлийг эд зүйл, баримт бичгээ хураалгасан болон тухайн ажиллагаанд байлцсан хүнээр гарын үсэг зуруулж, хувийг эд зүйлийн эзэмшигч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид даруй гардуулах.
		Хэрэгт ач холбогдолтой цахим баримтыг хуулбарлан авах, эсхүл түүнийг устгах, нэвтрэх боломжийг хязгаарлах боломжгүй бол цахим төхөөрөмжийг хураан авах.
		Түр хураан авсан хөрөнгийн эх үүсвэр нь хууль бус тогтоогдвол “Хөрөнгө эрхлэн удирдах нэгж”-д хариуцуулах санал гаргах
	Хөрөнгө шалгах ажиллагааны шийдвэр	- Хөрөнгө шалгах ажиллагааны явцад тухайн хөрөнгө хууль ёсны болох нь тогтоогдвол хөрөнгө шалгах ажиллагааг хаах саналтай прокурорын хяналтад шилжүүлэх - Хэрэв нийтийн албан тушаалтны хөрөнгө хууль бус болох нь тогтоогдвол хууль бус хөрөнгийг хураан авч, улсын орлого болгуулах тухай саналтай прокурорын хяналтад шилжүүлэх.

Хуулийн төслийн дагуу прокурорын байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээний стандарт үйл ажиллагааг тодорхойлъё.

Хүснэгт.3 Прокурорын байгууллагын стандарт үйл ажиллагаа

Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа
Прокурор	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох	Шүүхэд хэргийн талаар үнэн зөв тайлбар гаргах;
		Шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага, түүнийг үгүйсгэх, татгалзах үндэслэл, тайлбар түүнтэй холбоотой баримтыг өөрөө нотлох, нотлох баримтыг цуглуулах, гаргаж өгөх;
		Шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх;

		Шүүхийн тавьсан шаардлагыг биелүүлэх;
		Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих;
		Шүүхийн шийдвэрийг гардаж авах, биелүүлэх.
	Оролцогчийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх;	Гэрч, шинжээч, мэргэжилтний өөрийн болон бусдын аюулгүй байдлаа хангуулах талаарх хүсэлтийг хүлээн авах;
		Хүсэлт, гомдлыг амаар, эсхүл бичгээр гаргах ба амаар гаргасан бол тэмдэглэлд тусгаж, хүлээн авсан албан тушаалтан, хүсэлт, гаргагч гарын үсэг зурах;
		Хүсэлтийг хуульд заасан журмын дагуу гаргасан, үндэслэлтэй гэж үзвэл гэрч, хохирогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээс бусад биеийн байцаалтыг мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгахгүйгээр тусад нь бичиж битүүмжлэн хавтаст хэрэгт хавсаргах;
		Хүсэлт, гомдол, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн баримт, тэмдэглэл, холбогдох бүх материалыг хавтаст хэрэгт хавсаргах;
	Гомдол гаргагчийн гаргасан гомдлыг шалган шийдвэрлэх	Оролцогч нь мөрдөгчийн шийдвэр, ажиллагаанд гаргах гомдлыг хяналт тавьж байгаа прокурорт, хяналт тавьж байгаа прокурорын шийдвэр, ажиллагааны талаарх гомдлыг тухайн нэгжийн дээд шатны прокурорт шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор гаргана.
		Гомдлыг хүлээн авсан прокурор 14 хоногийн дотор, нэмэлт материал шалгах, эсхүл бусад арга хэмжээ авах бол 21 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.
		Гомдлыг хянасан албан тушаалтан, прокурорын зүгээс мөрдөгч, прокурорын шийдвэр, ажиллагааг хүчингүй болгох, өөрчлөх, эсхүл гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай шийдвэр гаргана.
		Гомдол гаргагчид гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн, түүний үндэслэл, уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шийдвэрийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор дээд шатны прокурорын газарт гомдол гаргаж болохыг тайлбарлана.
	Прокурор хөрөнгө шалгах ажиллагаа явуулахдаа хаалттай болон	Мөрдөгчийн саналыг хүлээн авах

	хязгаарлалттай мэдээлэл агуулсан баримт бичиг, мэдээллийг цуглуулж, мэдээллийг хамгаалахад шаардлагатай арга хэмжээг авах	Прокурор саналыг хүлээн авснаас хойш даруй зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх
		Нотариат, банк, даатгалын болон арилжааны нууц, банк, банк бус санхүүгийн байгууллага дахь гүйлгээ, зээлийн нэмэлт мэдээлэл гаргуулан авахад мөрдөгчид зөвшөөрөл олгох
	Шинжилгээ хийлгэх	Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд ШШТХ-ийн 8.2-т заасан этгээдэд шинжилгээ хийлгэх санал тавих;
		Шинжээчийн хувийн баримт бичиг, тусгай мэдлэг, мэргэжил, чадварыг нотолсон баримт бичиг, шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзах үндэслэл, шинжээчээр ажиллахыг зөвшөөрч байгаа эсэхийг урьдчилан тодруулж баримтжуулах;
		Шинжилгээ хийлгэх тухай шийдвэр гаргах. Шүүх шинжилгээний тухай хуулийн 7.3-т заасан зүйлийг тусгаж бичих; 7.3.Шинжилгээ хийлгэх шийдвэрт дараах зүйлийг тусгана: 7.3.1.шинжилгээ хийлгэх үндэслэл; 7.3.2.шинжилгээний төрөл, хэлбэр; 7.3.3.энэ хуулийн 16.7-д заасан жишиг хугацааны хүрээнд тогтоосон шинжилгээ хийлгэх хугацаа; 7.3.4.шинжилгээ хийх байгууллагын нэр; 7.3.5.шинжилгээний байгууллагаас бусад этгээдээр шинжилгээ хийлгэх бол байгууллага, шинжээчийн нэр; 7.3.6.шинжээчид тавих асуулт; 7.3.7.хэмжээ, хаяг, байршил зэрэг шинжилгээний объектын талаарх мэдээлэл.
		Шинжилгээ хийлгэх шийдвэрийг гардуулан өгөх;
		Шинжээчийн Эрх, үүрэг, хариуцлагыг урьдчилан сануулж, гарын үсэг зуруулах;
	Нийтийн албан тушаалтны хөрөнгийг битүүмжлэх тухай шийдвэр гаргах	Тухайн хөрөнгийг байгаа газарт нь битүүмжлэх шийдвэр гаргах
		Мөрдөгчид өгөх
	Хөрөнгийг түр хураан авах тухай шүүхэд санал гаргах	Дараах үндэслэлүүдийг шалгах: 41.1.1.хөрөнгийг устгах, захиран зарцуулах, өмчлөгч, эзэмшигчийг өөрчлөх;

		41.1.2.хөрөнгийн үнийг илтэд нөлөөлөх бодит нөхцөл бий болсон;
		41.1.3.хөрөнгийг гэмт хэрэг үйлдэхэд ашиглах боломжтой;
		41.1.4.тухайн хөрөнгө үрэгдэх, тоногдох, шинж чанарыг өөрчлөх болон хөрөнгийг цаашид хураах боломжгүй болгох бусад эрсдэл байвал.
	Мөрдөгчид хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах зөвшөөрөл олгох	Түр хураан авах тухай Мөрдөгчийн саналыг хүлээн авах
		Түр хураан авах тухай шүүхэд хүсэлт гаргах
		Мөрдөгчийн хүсэлттэй танилцах
	Түр хураан авсан хөрөнгийг шийдвэрлэх тухай санал гаргах	Хөрөнгийн шилжилт, хөдөлгөөнийг хянах, хязгаарлах зөвшөөрөл олгох
		Түр хураан авсан хөрөнгийг Хөрөнгө эрхлэн удирдах нэгжид шилжүүлэх саналыг шүүхэд гаргах
		Шүүхийн шийдвэрийг хүлээн авах, танилцах
		Тухайн шийдвэрийг хөрөнгийн эзэмшигч, өмчлөгч, ашиглагч, холбогдогч, түүний өмгөөлөгчид 5 хоногийн дотор танилцуулах
	Шалгах ажиллагааны хэргийн материалыг бүртгэж, хөтлөх	Хүсэлт, гомдол, мэдээлэл, шалгах ажиллагааны шийдвэр, бусад баримт бичиг, эд зүйлийн талаар тэмдэглэл үйлдэх;
		Төрийн албан хэрэг хөтлөх журмын дагуу бүртгэх;
		Хүсэлт, гомдол, мэдээлэл, шалгах ажиллагааны шийдвэр, бусад баримт бичгийг хэргийн материалд тусгаж, хавсаргах;
		Мөрдөгчийн саналыг хүлээн авах
	Мөрдөн шалгах ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох	Саналтай танилцах
		Зөвшөөрөл олгох эсэх шийдвэр гаргах
		Энэ хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай прокурорын зөвшөөрөлд дараахь зүйлийг тусгана:
		3.1.ажиллагааны нэр; 3.2.ажиллагааны зорилго; 3.3.ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан; 3.4.ажиллагаа явуулах газар, нэвтрэх, дамжин орох орон байрны хаяг, эзэмшил газрын байршил; 3.5.ажиллагаанд хамрагдах хүн, хуулийн этгээд, байгууллага, объект; 3.6.ажиллагаа явуулах хугацаа; 3.7.ажиллагааны явцад хүний

		эрхийг хангах арга хэмжээ; 3.8.зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа; 3.9.зөвшөөрөл олгосон прокурорын нэр, он, сар, өдөр.
	Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох	Мөрдөгчийн саналыг хүлээн авах Саналтай танилцах Зөвшөөрөл олгох эсэх шийдвэр гаргах Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах тухай прокурорын зөвшөөрөлд төрийн нууцыг хамгаалах зорилгоор ЭХХШТХ-ийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан мэдээллийг хязгаарлаж болно.
	Хөрөнгө шалгах ажиллагааны талаарх мэдээллийг нийтлэх зөвшөөрөл олгох	Хөрөнгө шалгах нэгжээс ирүүлсэн хүсэлт, мэдээлэлтэй танилцах Хөрөнгө шалгах нэгжид хөрөнгө шалгах ажиллагааны мэдээллийг нийтэд мэдээлэх зөвшөөрлийг олгох
	Хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх тухай бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн хэргийг прокурор шүүхэд шилжүүлнэ.	Хууль бус хөрөнгө өмчлөгч, эзэмшигч, холбогдогч нь хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх хүсэлтийг хүлээн авах Хүсэлтэд үндэслэн хэргийг шүүхэд шилжүүлэх Холбогдох баримт, материалыг хавсаргах
	Прокурор нэхэмжлэл гаргахдаа нэхэмжлэлийн үндэслэл, шаардлагыг тодорхойлж, холбогдох баримтыг хавсарган нэхэмжлэлийг шүүхэд хүргүүлнэ.	Нэхэмжлэлийн үндэслэл, шаардлагыг тодорхойлох Хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг прокурор иргэний хэргийн анхан шатны шүүхэд Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан харьяаллын дагуу гаргана. Холбогдох баримт, материалыг хавсаргах Нэхэмжлэлийг шүүхэд хүргүүлэх
	Хууль бус хөрөнгө хураах ажиллагааны цахим мэдээллийн санг хөтлөх	Цахим мэдээллийн сан үүсгэх Нэвтрэх эрх бүхий байгууллагуудыг бүртгэх Хууль бус хөрөнгийн мэдээллийг бүртгэх Цахим мэдээллийн санг хөтлөх

Хуулийн төслөөр Ерөнхий прокурорын газрын гүйцэтгэх үүргийн стандарт үйл ажиллагааг тодорхойлъя.

Хүснэгт.4 Ерөнхий прокурорын газрын стандарт үйл ажиллагаа

Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа
---------------------------------	---	------------------------

Ерөнхий прокурорын газар	Ерөнхий прокурорын газар нь гадаад улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн, хөрөнгө илрүүлэн тогтоох, хөрөнгийн мэдээлэл авах хүсэлтийг хангах зорилгоор хуульд заасан холбогдох арга хэмжээг авах	Хууль бус хөрөнгө хураах тухай гадаад улсын шүүхийн шийдвэр, тус шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн арга хэмжээг олон улсын гэрээ болон эрх зүйн харилцан туслалцааны үндсэн дээр хүлээн зөвшөөрөх
		Ерөнхий прокурорын газар нь гадаад улсын эрх бүхий байгууллагаас хөрөнгө хураан авахтай холбогдох шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг хүлээж авсан даруй тухайн шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэхээр хуульд заасны дагуу гүйцэтгэх хуудас гаргуулах тухай хүсэлтийг шүүхэд гаргах
		Ерөнхий прокурорын газар нь хийсэн ажиллагаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудасны талаар хүсэлт илгээсэн байгууллагад нэн даруй мэдэгдэх
		Олон улсын гэрээ, эсхүл энэ хуульд заасны дагуу гадаад улсын эрх бүхий байгууллагаас хүлээн авсан хүсэлтийг биелүүлэх нь дотоодын хууль тогтоомжтой харшлах буюу бусад шалтгаанаар боломжгүй бол гадаад улсын холбогдох байгууллагад хүсэлтийг биелүүлэх боломжгүй болсон шалтгааны талаар мэдэгдэх
		Гадаад улсын нутаг дэвсгэрт байгаа хөрөнгийн талаар мэдээлэл авах, хөрөнгийг битүүмжлэх, хөрөнгийн хөдөлгөөнийг хязгаарлах, түр хураан авах, хураан авах талаар прокурор, шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэх арга хэмжээ авах хүсэлтийг Ерөнхий Прокурорын газар гадаад улсын эрх бүхий байгууллагад хүргүүлэх

Хуулийн төслийн дагуу шүүхийн гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээний стандарт үйл ажиллагааг тодорхойлъё.

Хүснэгт.4 Шүүхийн стандарт үйл ажиллагаа

Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл Ажиллагаа
Шүүх	Оролцогчийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх	Гэрч, шинжээч, мэргэжилтний өөрийн болон бусдын аюулгүй байдлаа хангуулах талаарх хүсэлтийг хүлээн авах;
		Хүсэлт, гомдлыг амаар, эсхүл бичгээр гаргах ба амаар гаргасан бол

		тэмдэглэлд тусгаж, хүлээн авсан албан тушаалтан, хүсэлт, гаргагч гарын үсэг зурах;
		Хүсэлтийг хуульд заасан журмын дагуу гаргасан, үндэслэлтэй гэж үзвэл гэрч, хохирогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээс бусад биеийн байцаалтыг мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгахгүйгээр тусад нь бичиж битүүмжлэн хавтаст хэрэгт хавсаргах;
		Хүсэлт, гомдол, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн баримт, тэмдэглэл, холбогдох бүх материалыг хавтаст хэрэгт хавсаргах;
	Шинжилгээ хийлгэх	Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд ШШТХ-ийн 8.2-т заасан этгээдэд шинжилгээ хийлгэх санал тавих;
		Шинжээчийн хувийн баримт бичиг, тусгай мэдлэг, мэргэжил, чадварыг нотолсон баримт бичиг, шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзах үндэслэл, шинжээчээр ажиллахыг зөвшөөрч байгаа эсэхийг урьдчилан тодруулж баримтжуулах;
		Шинжилгээ хийлгэх тухай шийдвэр гаргах. Шүүх шинжилгээний тухай хуулийн 7.3-т заасан зүйлийг тусгаж бичих;
		7.3.Шинжилгээ хийлгэх шийдвэрт дараах зүйлийг тусгана:
		7.3.1.шинжилгээ хийлгэх үндэслэл;
		7.3.2.шинжилгээний төрөл, хэлбэр;
		7.3.3.энэ хуулийн 16.7-д заасан жишиг хугацааны хүрээнд тогтоосон шинжилгээ хийлгэх хугацаа;
		7.3.4.шинжилгээ хийх байгууллагын нэр;
		7.3.5.шинжилгээний байгууллагаас бусад этгээдээр шинжилгээ хийлгэх бол байгууллага, шинжээчийн нэр;
		7.3.6.шинжээчид тавих асуулт;
		7.3.7.хэмжээ, хаяг, байршил зэрэг шинжилгээний объектын талаарх мэдээлэл.
		Шинжилгээ хийлгэх шийдвэрийг гардуулан өгөх;
		Шинжээчийн Эрх, үүрэг, хариуцлагыг урьдчилан сануулж, гарын үсэг зуруулах;
	Эд хөрөнгө битүүмжлэх тухай шийдвэр гаргах	Тухайн хөрөнгийг байгаа газарт нь битүүмжлэх шийдвэр гаргах
		Прокурорт өгөх

	Хөрөнгийг түр хураан авах тухай шийдвэр гаргах	Түр хураан авах тухай мөрдөгч прокурорын саналтай танилцах
		Хөрөнгийг түр хураан авах тухай шийдвэр гаргах
	Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь оролцогч, бусад оролцогчоос гаргасан хүсэлт, гомдол, мэдээлэл, шалгах ажиллагааны шийдвэр, бусад баримт бичиг, эд зүйлийг тэмдэглэл үйлдэж, эсхүл төрийн албан хэрэг хөтлөх журмын дагуу бүртгэж, хэргийн материалд тусгаж, хавсаргах	Оролцогч, бусад оролцогчоос гаргасан хүсэлт, гомдол, мэдээлэл, шалгах ажиллагааны шийдвэр, бусад баримт бичиг, эд зүйлийг тэмдэглэл үйлдэх
		төрийн албан хэрэг хөтлөх журмын дагуу бүртгэх
		хэргийн материалд тусгаж, хавсаргах
	Шүүх хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай шийдвэр гаргах	Нотлох баримтад үндэслэн шийдвэр гаргах
		Шүүх хууль бус хөрөнгийг хураан авсан, нөхөн төлүүлсэн тухай шийдвэртээ тухайн хөрөнгийг улсын орлого болгож төрийн өмчид шилжүүлэх талаар тусгах

2.1.1 Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана. Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистикт тоон мэдээллийг тооцсон болно.


2.1.1.1 Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Хуулийн төслийн чиг үүргүүдийг хэрэгжүүлэхэд тус байгууллагад шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлъё.

Хуулийн төслийн 49.1 дэх хэсэгт заасны дагуу *“Шалгах ажиллагаа нь хоёр жил хүртэл хугацаанд үргэлжилж болох бөгөөд олон улсын хамтын ажиллагааны журмаар илгээсэн хүсэлтийг биелүүлэх, эсхүл олон улсын хамтын ажиллагааны журмаар хүлээн авсан мэдээллийн үндсэн дээр ажиллагаа явуулах шаардлагатай болсон бол прокурорын шийдвэрээр тус хугацааг нэг жил хүртэл хугацаагаар сунгаж болно”* гэж заасан. Иймд стандарт үйл ажиллагаануудыг тасралтгүй шинжтэй үргэлжлэх ажил гэж үзнэ. Өөрөөр хэлбэл энэ тохиолдолд стандарт үйл ажиллагаа бүрт зарцуулах хугацааг тодорхойлох нь ач холбогдолгүй байна.

Харин хүний нөөцийн хэрэгцээг тухайн жилд шалгах ажиллагааны дундаж тоонд үндэслэн тооцох нь үр дүнтэй юм.

Ерөнхий Прокурорын газрын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны мэдээллээр 2017 оноос 2024 оны эхний 8 сарын байдлаар Эрүүгийн хэргийн тусгай ангийн 22 дугаар бүлэгт заасан, давхардсан тоогоор авлигын 8712 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, прокуророос хяналт тавьж ажилласан гэв.



Авилгатай тэмцэх газар 2023 онд өмнөх оны 141, шинээр хүлээн авсан гэмт хэргийн талаарх 2,015, нийт 2,156 гомдол, мэдээллийг хүлээн авснаас 427 гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу харьяалах байгууллагад нь шилжүүлж, гэмт хэргийн талаарх 1,670 гомдол, мэдээллийг бүртгэлд оруулан шалгасан байна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1,670 гомдол, мэдээллээс 701 гомдол, мэдээлэл буюу 41.9 хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, 870 гомдол, мэдээлэл буюу 52.1 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 44 гомдол, мэдээлэл буюу 2.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, 55 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 96.7 хувьтай байна.²

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн мэдээллээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн дараах тоон мэдээлэл байна.

2017 он -15
2018 он -25
2019 он -47
2020 он -116
2021 он -148
2022 он -182
2023 он -188

Цагдаагийн байгууллагаас 2019-2023 онд мөнгө угаах гэмт хэргээр зүйлчлэн мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн статистик мэдээллийг он, оноор дэлгэрэнгүй танилцуулбал,

2020 онд Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл /Мөнгө угаах/-ээр давхар зүйлчлэн нийт 218 хэрэг, хамтарсан ажлын хэсгээс 3 хэрэг, нийт 221 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нийт 221 хэргээс:

- Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан - 49
- Нэгтгэгдсэн - 8
- Хэрэгсэхгүй болгосон – 1
- Яллах дүгнэлт үйлдсэн - 76
- Шүүхээр шийдэгдсэн- 71 хэрэг

2021 онд Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл /Мөнгө угаах/-ээр давхар зүйлчлэн нийт 277 хэрэг, хамтарсан ажлын хэсгээс 4 хэрэг, нийт 267 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нийт **267** хэргээс:

- Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан - 32
- Нэгтгэгдсэн - 52
- Хэрэгсэхгүй болгосон -1
- Яллах дүгнэлт үйлдсэн - 64

2022 онд Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл /Мөнгө угаах/-ээр давхар зүйлчлэн нийт 277 хэрэг, хамтарсан ажлын хэсгээс 4 хэрэг, нийт 267 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нийт **257** хэргээс:

- Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан - 44
- Нэгтгэгдсэн - 63
- Хэрэгсэхгүй болгосон -2
- Яллах дүгнэлт үйлдсэн - 79
- Түдгэлзүүлсэн -3
- Шүүхээр шийдэгдсэн- 76

² Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал 2023, тайлан 2024 он



2023 онд Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл /Мөнгө угаах/-ээр давхар зүйлчлэн нийт 2712 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нийт **212** хэргээс:

- Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан - 44
- Нэгтгэгдсэн - 63
- Хэрэгсэхгүй болгосон -2
- Яллах дүгнэлт үйлдсэн - 79
- Түдгэлзүүлсэн -3
- Шүүхээр шийдэгдсэн- 76

Хуулийн төслийн 4.1.10-т заасан буюу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуульд заасан дор дурдсан дагуу албан тушаалтнууд болон хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын болон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан тушаалтнаар томилогдон, эсхүл сонгогдон, түр болон байнгын орон тоон дээр ажиллаж байгаа болон ажиллаж байсан хүн хуулийн үйлчлэлд хамаарахаар байна.

- 4.1.1.төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;*
- 4.1.2.төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;*
- 4.1.3.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;*
- 4.1.4.олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;*
- 4.1.5.улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;*
- 4.1.6.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;*
- 4.1.7.бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;*
- 4.1.8.эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан;*
- 4.1.9.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.*

Хуулийн төслийн 29.1-д “Прокурор нь хууль бус хөрөнгөтэй холбоотой хөрөнгө шалгах ажиллагааны явцад мэдэгдэж буй нөхцөл байдлыг үндэслэн шалгах ажиллагаа явуулах тухай шийдвэр гаргахдаа шалгах ажиллагаанд 2002 оны 9 сарын 01-ний өдрөөс хойш бий болсон хууль бус хөрөнгийг хамруулна.” гэж шалгах ажиллагааны хамрах хугацааг тодорхойлсон тул уг хугацаанаас шалтгаалан энэ хуулийн үйлчлэлд дээр дурдсан албан тушаалд ажиллаж байсан нийт 3000 гаруй албан тушаалтан болон түүний хамаарал бүхий этгээдийг шалгахаар байна.

Хуулийн төслийн 49.1 дэх хэсэгт заасны дагуу “Шалгах ажиллагаа нь хоёр жил хүртэл хугацаанд үргэлжилж болох бөгөөд олон улсын хамтын ажиллагааны журмаар илгээсэн хүсэлтийг биелүүлэх, эсхүл олон улсын хамтын ажиллагааны журмаар хүлээн авсан мэдээллийн үндсэн дээр ажиллагаа явуулах шаардлагатай болсон бол

прокурорын шийдвэрээр тус хугацааг нэг жил хүртэл хугацаагаар сунгаж болно” гэж заасан. Иймд хөрөнгө хураах ажиллагаа тохиолдол бүрт 2-3 жил зарцуулахаар байна. Мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагууд нэг жилд нийт 1000 гаруй нийтийн албан тушаалтан түүний хамаарал бүхий этгээдийн хөрөнгө шалгах ажиллагааг гүйцэтгэнэ гэж тооцоолж, тусгайлсан нэгжийн нэг мөрдөгч жилд дунджаар 30 хэрэг дээр ажиллана³ гэх байдлаар хүний нөөцийн ачааллыг тооцъё.

Харин шүүх болон прокурорын байгууллагын хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагаа нь тодорхой тохиолдлуудад зөвшөөрөл олгох болон шийдвэр гаргах үйл ажиллагаатай түлхүү хамааралтай байх тул дээр дурдсан шүүхийн шийдвэрлэсэн маргааны тоонд үндэслэу жилд зарцуулах хугацааг богиносгон хүний нөөцийн ачааллыг тооцъё.

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200x8) 1600 ажлын цаг буюу (1600x60) 96.000 минут ажиллана. Хуулийн төслийн 29.1-д заасны дагуу 2 жилээр хугацааг тооцоолвол 192.000 мин байна. Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 5. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
Авлигатай тэмцэх газар	Стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэх	3,168,000	96000	33
Цагдаагийн байгууллага	Стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэх	3,168,000	96000	33
Тагнуулын байгууллага	Стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэх	3,168,000	96000	33
Прокурор	Стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэх	960,000	96000	10
Шүүх	Стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэх	192,000	96000	1
Нийт				110

Хүснэгт 6. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

³ Цагдаагийн ерөнхий газар, Цагдаагийн ачаалал <https://gogo.mn/r/en30m>, 2021 он

Гүйцэтгэх байгууллага	Үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Авлигатай тэмцэх газар	Стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэх	3,168,000	1	3,168,000
Цагдаагийн байгууллага	Стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэх	3,168,000	1	3,168,000
Тагнуулын байгууллага	Стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэх	3,168,000	1	3,168,000
Прокурорын байгууллага	Стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэх	960,000	1	960,000
Шүүх	Стандарт үйл ажиллагааг хэрэгжүүлэх	192,000	1	192,000
Нийт				10,656,000

Тухайн жилийн турш стандарт үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх тул тохиолдлын тоог 1-р тооцно. Хууль бус хөрөнгө хураах ажиллагааг хэрэгжүүлэхэд жилд нийт 10,656,000 минут зарцуулах ба шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ АТГ, цагдаа, прокурорын **байгууллага тус бүр 33** байна. Энэ нь жилд 1000 орчим хууль бус хөрөнгө шалгах ажиллагааг хийх боломжтой гэсэн үг юм.

2.1.1.2 Гарах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улсаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Цагдаагийн байгууллагын мөрдөгчийн цалинг тогтоохдоо Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 26 дугаар тогтоолын хавсралт “Төрийн тусгай албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалт” Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ”, Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Цагдаагийн алба хаагчийн төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам, Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Цагдаагийн алба хаагчдад албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт Цагдаагийн алба хаагчдад мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам”, Монгол улсын засгийн газрын тогтоол 2024 оны 12 сарын 04-ний өдрийн 202 дугаар “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн цолны нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолыг тус тус үндэслэв.

Мөрдөгчийн дундаж цалинг ТТ-7 зэрэглэл буюу үндсэн цалингийн хэмжээ нь 1,633,000 төгрөг байхаар тооцов.⁴ Уг үндсэн цалин дээр нэмэгдэл, урамшууллыг нэмж

⁴ Төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ (сард, төгрөгөөр)

ТТ-1 2,189,000

ТТ-2 2,085,000

ТТ-3 1,985,000

ТТ-4 1,891,000

тооцсон дүнгээр олговол зохих цалин нь дунджаар 2,843,440 төгрөг байна. Үүнээс 1 жилд олговол зохих цалин нь 34,121,280 төгрөг, түүнд ногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь 12.5 хувь буюу сард 355,430 төгрөг буюу жилд 4,265,165 төгрөг болно. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь жилд дунджаар **38,386,445** төгрөг байна.

ТЕГ-ын мөрдөгчийн цалинг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 121 дүгээр тогтоолын хавсралт “Тагнуулын байгууллагын албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам” болон (ТЕГ-ын албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээ нь нийтэд нээлттэй биш байх тул) текст-анализын аргад тулгуурлан авсан мэдээллээр 6,000,000 төгрөг байхаар тооцов. Үүнээс 1 жилд олговол зохих цалин нь 72,000,000 төгрөг, түүнд ногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь 12.5 хувь буюу сард төгрөг буюу жилд 9,000,000 төгрөг болно. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь жилд дунджаар **81,000,000** төгрөг байна.

АТГ-ын мөрдөгчийн цалинг Монгол Улсын Их Хурлын 2023 оны 92 дугаар тогтоолын хавсралт “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ”, Монгол Улсын Их Хурлын 2007 оны 07 дугаар тогтоолын хавсралт Авлигатай тэмцэх газрын албан хаагчид зэрэг дэв, нэмэгдэл олгох журмыг тус тус үндэслэн тооцов. Иймд АТГ-ын албан хаагчийн үндсэн цалинг 3,293,035 төгрөгөөр тооцов. Уг үндсэн цалин дээр нэмэгдэл, урамшууллыг нэмж тооцсон дүнгээр олговол зохих цалин нь дунджаар 4,280,945 төгрөг байна. Үүнээс 1 жилд олговол зохих цалин нь 51,371,346 төгрөг, түүнд ногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь 12.5 хувь буюу сард төгрөг буюу жилд 6,421,418 төгрөг болно. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь жилд дунджаар **57,792,764** төгрөг байна.

Хүснэгт 7. АТГ-ын цалингийн хэмжээ

Д/д	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ /төгрөгөөр/
1	Авлигатай тэмцэх газрын дарга	4 338 298
2	Авлигатай тэмцэх газрын дэд дарга	4 041 128
3	Хэлтсийн дарга	3 984 234
4	Албаны дарга	3 670 140
5	Ахлах ажилтан	3 493 365
6	Ажилтан	3 293 035
7	Туслах ажилтан	1 880 970

Прокурорын цалинг тогтоохдоо, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 117 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт “Прокурорын байгууллагын прокурорын албан тушаалын цалингийн хэмжээ”, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 07 сарын 07-ны өдрийн 72 дугаар тогтоол “Прокурорын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай”, Монгол Улсын Их Хурлын 2018 оны 66 дугаар тогтоолын хавсралт “Прокурорын зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээ”, Улсын Их Хурлын 58 дугаар тогтоолын

ТТ-5 1,800,000
ТТ-6 1,715,000
ТТ-7 1,633,000
ТТ-8 1,555,000
ТТ-9 1,482,000
ТТ-10 1,411,000
ТТ-11 1,283,000
ТТ-12 1,166,000

2-р хавсралт “Прокурорт төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ыг тус тус үндэслэн тогтоов.

Хүснэгт 8. Прокурорын цалингийн хэмжээ

Д/д	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ /төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхий прокурор	5 205 000
2	Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч	5 055 000
3	Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, хэлтсийн дарга, Нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурор	4 905 000
4	Аймаг, тээвэр, дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор, Улсын Ерөнхий прокурорын газрын ахлах прокурор, Нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч	4 735 000
5	Улсын Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор, Нийслэлийн прокурорын газрын ахлах прокурор	4 545 000
6	Сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор, Аймаг, тээвэр, дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч	4 395 000
7	Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор, Аймаг, тээвэр, дүүргийн прокурорын газрын ахлах прокурор	4 195 000
8	Аймаг, тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрын хяналтын прокурор	3 995 100

Прокурорын үндсэн цалингийн хэмжээ нь 4,195,000 төгрөг байхаар тооцов. Уг үндсэн цалин дээр нэмэгдэл, урамшууллыг нэмж тооцсон дүнгээр олговол зохих цалин нь дунджаар 5,873,000 төгрөг байна. Үүнээс 1 жилд олговол зохих цалин нь 70,476,000 төгрөг, түүнд ногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь 12.5 хувь буюу сард 734,125 төгрөг буюу жилд 8,809,500 төгрөг болно. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь жилд дунджаар **79,285,500** төгрөг байна.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 117 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт бүх шатны шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ, Монгол Улсын Их Хурлын 2021 он 04 дугаар тогтоол “Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай”-г тус тус үндэслэв. Анхан шатны шүүхийн шүүгчийн үндсэн цалин 4,266,000 төгрөг байна. Уг үндсэн цалин дээр нэмэгдэл, урамшууллыг нэмж (Шүүн таслах ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээ үндсэн цалингийн 40 хувь буюу 1,706,400 төгрөг, докторын зэргийн нэмэгдэл 20 хувь буюу 845,200 төгрөг) тооцсон дүнгээр олговол зохих цалин нь дунджаар нэг сарын **6,817,600** төгрөг байна.

Хүснэгт 9. Шүүгчийн цалингийн хэмжээ

Д/д	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ (төгрөгөөр)
1	Хяналтын шатны шүүхийн Ерөнхий шүүгч	5 214 000
2	Хяналтын шатны шүүхийн шүүгч	5 056 000
3	Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч	4 740 000
4	Давж заалдах шатны шүүхийн шүүгч	4 582 000
5	Анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	4 424 000
6	Анхан шатны шүүхийн шүүгч	4 266 000

Энэ зардлаа дээр тооцож гаргасан **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 10. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал (төгрөгөөр)
Авлигатай тэмцэх газар	33	57,792,764	1,907,161,212
Цагдаагийн байгууллага	33	38,386,445	1,266,752,685
Тагнуулын байгууллага	33	81,000,000	2,673,000,000
Прокурорын байгууллага	2	79,285,500	158,571,000
Шүүх	1	6,817,600	6,817,600

2.1.1.3 Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, хүний нөөцийн нэмэгдсэн ажлын ачаалалд ногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 11. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал

Зардлын төрөл	Зардлын нэр	1 жилд зарцуулах зардал (төгрөгөөр)
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	53,725
Зардал	Түлш, халаалт	199,897
	Гэрэл, цахилгаан	937,251
	Цэвэр, бохир ус	51,947
	Урсгал засвар	53,725
	Газрын төлбөр	1411
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	356,555
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид ногдох нийт зардал		5,395,434

Хүснэгт 12. Төрийн байгууллагын нэмэгдэж буй материаллаг зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн материаллаг зардал	Нийт материаллаг зардал (төгрөгөөр)
Авлигатай тэмцэх газар	33	5,395,434	178,049,322
Цагдаагийн байгууллага	33	5,395,434	178,049,322
Тагнуулын байгууллага	33	5,395,434	178,049,322
Прокурорын байгууллага	2	5,395,434	10,790,868
Шүүх	1	5,395,434	5,395,434

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 13. Нийт зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (хүний тоо)	Хүний нөөцийн зардал (төгрөгөөр)	Материаллаг зардал (төгрөгөөр)
Авлигатай тэмцэх газар	33	1,907,161,212	178,049,322
Цагдаагийн байгууллага	33	1,266,752,685	178,049,322
Тагнуулын байгууллага	33	2,673,000,000	178,049,322
Прокурорын байгууллага	2	158,571,000	10,790,868
Шүүх	1	6,817,600	5,395,434
Нийт	102	6,012,302,497	550,334,268


Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд төрийн байгууллагад хүний нөөцийн цалингийн зардалд **6,012,302,497** нийт төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд **550,334,268** төгрөг, нийт төгрөгийн зардал үүсэхээр байна.

2.1.1.4 Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх:

Төрийн байгууллагын зардал тооцох хүрээнд, хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг тухайн төрийн байгууллага жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог “тохиолдлын тоо” гэж авч үздэг. Хуулийн төслийн 4.1.10-т “нийтийн албан тушаалтан” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 4 дүгээр зүйлийн 4.1, Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 - 4.1.9-д заасан этгээдээс гадна хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын болон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан тушаалтнаар томилогдон, эсхүл сонгогдон, түр болон байнгын орон тоон дээр ажиллаж байгаа болон ажиллаж байсан хүнийг ойлгоно гэж, 29.1-т Прокурор нь хууль бус хөрөнгөтэй холбоотой хөрөнгө шалгах ажиллагааны явцад мэдэгдэж буй нөхцөл байдлыг үндэслэн шалгах ажиллагаа явуулах тухай шийдвэр гаргахдаа шалгах ажиллагаанд 2002 оны 9 сарын 01-ний өдрөөс хойш бий болсон хууль бус хөрөнгийг хамруулна гэж, 49.1.Шалгах ажиллагаа нь хоёр жил хүртэл хугацаанд үргэлжилж болох бөгөөд олон улсын хамтын ажиллагааны журмаар илгээсэн хүсэлтийг биелүүлэх, эсхүл олон улсын хамтын ажиллагааны журмаар хүлээн авсан мэдээллийн үндсэн дээр ажиллагаа явуулах шаардлагатай болсон бол прокурорын шийдвэрээр тус хугацааг нэг



жил хүртэл хугацаагаар сунгаж болно гэж тус тус заасны дагуу хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа нь тасралтгүй үргэлжлэх шинжтэй ажил тул тохиолдлын тоог бууруулах боломжгүй байна.

Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;

Хуулийн төсөлд заасан процесс ажиллагаанууд нь түлхүү Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гүйцэтгэхээр байх тул тус ажиллагаануудыг хялбарчлах буюу үе шатыг алгасах, багасгах боломжгүй гэж үзэж байна.

Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;

Хуулийн төсөлд хууль бус хөрөнгө хураах ажиллагааны цахим мэдээллийн сантай байх талаар зохицуулалт тусгасан. Одоогийн байдлаар прокурорын байгууллага нь эрүүгийн хэргийн нэгдсэн цахим системийг 2013 оноос ашиглаж байх ба тус мэдээллийн санд тохирох өөрчлөлтүүдийг хийх, өргөжүүлэх замаар зардлыг бууруулах боломжтой байна.

V. ДҮГНЭЛТ

Хуулийн төсөлтэй холбогдон гарах зардлыг урьдчилан тодорхойлох, цаашид ачааллыг багасгах санал боловсруулах зорилгоор энэхүү судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг баримтлан тооцоолов.

Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо: Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан хууль бус хөрөнгө хураан авах ажиллагааг шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газар, цагдаа, тагнуулын байгууллага дахь тусгайлсан нэгжийн мөрдөгч хэрэгжүүлнэ”, 7.2-д “Энэ хуулийн 3.2-т заасан ажиллагааг шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газрын мөрдөгч хэрэгжүүлнэ” гэж хууль бус хөрөнгийг хураан авах ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагыг тодорхойлсон. Энэ зүйлд үндэслэн хуулийн төслөөс мөрдөгч, прокурор болон шүүгчийн гүйцэтгэх үүргийг түүвэрлэж, үүрэг бүрийн стандарт үйл ажиллагааг тогтоов.

Хуулийн төслийн 49.1 дэх хэсэгт заасны дагуу “Шалгах ажиллагаа нь хоёр жил хүртэл хугацаанд үргэлжилж болох бөгөөд олон улсын хамтын ажиллагааны журмаар илгээсэн хүсэлтийг биелүүлэх, эсхүл олон улсын хамтын ажиллагааны журмаар хүлээн авсан мэдээллийн үндсэн дээр ажиллагаа явуулах шаардлагатай болсон бол прокурорын шийдвэрээр тус хугацааг нэг жил хүртэл хугацаагаар сунгаж болно” гэж заасан. Иймд хөрөнгө хураах ажиллагаа нь тохиолдол бүрт 2-3 жил зарцуулах тул стандарт үйл ажиллагааг жилийн туршид тасралтгүй үргэлжлэх шинжтэй гэж тогтоосон болно.

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд төрийн байгууллагад хүний нөөцийн цалингийн зардалд **6,012,302,497** нийт төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд **550,334,268** төгрөг, нийт **6,562,636,765** төгрөгийн зардал үүсэхээр байна. Тус зардлыг багасгахын тулд хөрөнгө хураах мөрдөн шалгах үүргийг тухайлсан нэг байгууллага хэрэгжүүлэх замаар бууруулах боломжтой гэж үзлээ.

Зардал-үр өгөөжийн харьцаа

ХТТХНӨТХ-ийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс гарах зардал өндөр байх боловч гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээнээс хэд дахин бага ба хууль бусаар олж авсан хөрөнгийг нөхөн төлүүлэх, хохирлыг барагдуулах хохирлын хэмжээ өндөр байх тохиолдолд хуулийн төслөөс үүдэх зардал нь эерэг нөлөөлөлтэй, үр өгөөжтэй байна.



ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж, эрх зүйн акт

1. Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016), №7;
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №23;
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
4. Монгол Улсын Их Хурлын 1996 оны 58 дугаар тогтоолын 2-р хавсралт “Прокурорт төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”;
5. Монгол Улсын Их Хурлын 2007 оны 07 дугаар тогтоолын хавсралт “Авлигатай тэмцэх газрын албан хаагчид зэрэг дэв, нэмэгдэл олгох журам”;
6. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 66 дугаар тогтоолын хавсралт “Прокурорын зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээ”;
7. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 07 сарын 07-ны өдрийн 72 дугаар тогтоол “Прокурорын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай”;
8. Монгол Улсын Их Хурлын 2021 он 04 дүгээр тогтоол “Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай”
9. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 117 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт “Прокурорын байгууллагын прокурорын албан тушаалын цалингийн хэмжээ”;
10. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 92 дугаар тогтоолын хавсралт “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ”;
11. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 117 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт “Бүх шатны шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ”;
12. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ”;
13. Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 26 дугаар тогтоолын хавсралт “Төрийн тусгай албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалт”;
14. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А264, А154 дугаар “Хөрөнгийн үнэлгээний шинжилгээ хийх журам” тушаалын хавсралт;

Бусад

1. Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал 2023, (УБ, 2024 он).
2. Цагдаагийн ерөнхий газар, “Цагдаагийн ачаалал”, (УБ, 2021 он) Холбоос:
<https://gogo.mn/r/en30m>